



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/349

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.1.1, засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны XIV/01 тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эрхийн зөрчлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын хүрээнд “Грийн бизнес өвнэр” ХХК-тай хамтран “Ээж” төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Санхүүжилт 50,000,000 (тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ